

“ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС” ТӨҮГ-ЫН ХУУЛЬ ХЯНАЛТ, ШҮҮХ, АРБИТРААР ШИЙДВЭРЛЭГДЭЖ БУЙ ХЭРГИЙН МЭДЭЭЛЭЛ
/2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар/

№	Хэргийн харьяалал	Хэргийн оролцогч	Нэхэмжлэлийн шаардлага	Хэрэг шийдвэрлэгдсэн байдал
1	Монголын Олон улсын арбитр	Нэхэмжлэгч: “Хархираат сарьдаг” ХХК Хариуцагч: “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ	MR-2023-02-39 Хамтран ажиллах гэрээг үргэлжлүүлэхийг даалгах	2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр арбитрын хуралдаан болж 541 дугаар шийдвэрээр “Хархираат сарьдаг” ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.
2	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх	Нэхэмжлэгч: “Батс-Өргөө” ХХК Хариуцагч: “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ	MR-2021-05-31 “Дахин төлөвлөлтийн барилгын /түлхүүр гардуулах нөхцөлтэй/ ажил гүйцэтгэх гэрээ, MR-2022-06-26 “Нэмэлт ажлын гэрээ”-ний үүргийн зөрчилтэй холбоотой алданги-970,837,906.97 төгрөг, хохирол 620,461,996 төгрөг, нийт 1,591,299,902.97 төгрөгийг хариуцагчаас гаргуулах.	2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр шүүх хуралдаан болж нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг буюу 28,527,590 төгрөгийн шаардлагыг хангаж үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.
3	Монголын Олон улсын арбитр	Нэхэмжлэгч: “Баянтэгш импекс” ХХК Хариуцагч: “Монголросцветмет” ТӨҮГ,	MR-2020-02-20 Хамтран ажиллах гэрээг хүчин төгөлдөрт тооцуулах, хохиролд 40,600,000 төгрөг гаргуулах, Эрдэнэс Монгол ХХК-ийн дотоод аудитын дүгнэлтийг хүчингүй болгуулах тухай	Арбитрын үндсэн хуралдаан 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр болж Нэхэмжлэлийн шаардлагыг хэсэгчлэн хангах Монголын олон улсын арбитрын 294 дугаар шийдвэр гарсан.2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Нийслэлийн давж заалдах шатны шүүх-д арбитрын 294 дугаар шийдвэрийг хүчингүй болгуулах тухай гомдол гаргасан. 2025 оны 06 дугаар сарын 02-ны Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн хурлаар арбитрын 294 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.
4	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх	Нэхэмжлэгч: “Альфа филтер” ХХК Хариуцагч: “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ,	Гэрээ байгуулах эрх олгох тухай Универсал жойнт ХХК-д хүргүүлсэн шийдвэрийг хүчингүй болгож тендер шалгаруулалтыг дахин зарлах	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд урьдчилсан хэлэлцүүлэг 2025 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр болж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамж гарсан.

5	Монголын Олон улсын арбитр	Нэхэмжлэгч: “Хазаарбат” ХХК Хариуцагч: “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ	Гэрээний үлдэгдэл төлбөрийг хариуцагч талаас гаргуулах.	Урьдчилсан хуралдаан болж 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр үндсэн хуралдаан товлогдсон боловч нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч шүүх хуралдаан давхацсан шалтгаанаар хуралдаан хойшилсон. Арбитрын хуралд гаргасан Нэхэмжлэгч талын шинжээч томилуулах хүсэлтийг хүлээн авсан.
6	Монголын Олон улсын арбитр	Нэхэмжлэгч: “Хустайн шил” ХХК Хариуцагч: “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ	MR-2022-02-03 Хамтран ажиллах гэрээг хүчин төгөлдөрт тооцуулах.	Урьдчилсан хурал 2025 оны 7 дугаар сарын 24 нд болж нэхэмжлэгчийн түр арга хэмжээ авхуулах хүсэлт болон хурлын журмыг хэлэлцсэн. Нэхэмжлэгч тал өөрийн томилсон арбитрчаас татгалзсан тул арбитрч нөхөн томилж, шинэ арбитрын бүрэлдэхүүн хурлын товыг зарлаагүй байна.
7	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх	Нэхэмжлэгч: Иргэн Б.Мөнхбат Хариуцагч: “Монголросцветмет” ТӨҮГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024.09.13-ны өдрийн 401 тоот тогтоолын хэрэгжилтийг хангуулах тухай	2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр гэрч асуух болон талуудын хүсэлтийг хэлэлцсэн. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.
8	Монголын Олон улсын арбитр	Нэхэмжлэгч: “Hainan telitai industrial” Co.,Ltd Хариуцагч: “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ	MRS-2023-01-18 дугаартай “Төмрийн хүдрийн хуурай баяжмал нийлүүлэх экспортын гэрээнээс үүдэлтэй 659,999.56 ам.долларыг хариуцагчаас гаргуулах	Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж хариу тайлбарыг хүргүүлсэн бөгөөд, урьдчилсан хуралдаан 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр товлогдсон.

Нэмэлт мэдээлэл, тодруулга авах: Хууль, Эрх зүйн хэлтсийн дарга Б.Алтансүх /11-458072 Дотуур утас 172/

-----oOo-----